



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/05/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	13
3.5.3 Урьдчилгаа.....	13
3.5.4 Бараа материал.....	14
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	14
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	14
3.5.7 Өр төлбөр.....	15
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	22
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага	22
5.3 Зөвлөмж.....	22
6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	23
7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24
7.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	24
7.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	25
7.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЭЭС	Эмийн эргэлтийн сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 0/229
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Л.АМГАЛАНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай "Түүхт ой бүтээн байгуулалтыг дэмжих жил" зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 21 чиглэлийн 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 93,1 хувьтай биелүүлж, "А" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төв аймгийн Заамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 01 тогтоолоор сумын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө баталсны дагуу ойн арга хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 23-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар орон нутагт төвлөрүүлэх

G/Архив/Албан бичиг 2024/ А4

07090520

орлогыг 97,6 хувиар биелүүлж, 2,4 хувиар буюу 93,187.3 мянган төгрөгөөр тасалж, 6 нэр төрлийн орлогыг 22,1-77,7 хувиар тасалсан байна.

Сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын төвдөө 3 км хатуу хучилттай авто замыг нийгмийн хариуцлагын гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.

Монголын баялаг 330 төслийн баг хамт олонтой хамтран ажиллах гэрээ байгуулан, 3 бүлэгтэй 30 минутын баримтат кино бүтээсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, дэд бүтцийн болон нийгмийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, сумын Засаг даргын 2018 оны А/603 дугаар захирамжаар 4 га газрын асуудлыг шийдвэрлэсэн “Заамар парк” цэцэрлэгт хүрээлэнд ёслол хүндэтгэлийн өргөө, сагсан бөмбөг, элсний волейбол, хөл бөмбөг, граунд гольфийн талбай, морин тойруулгын тоглоом, кофе шопын барилга, автомашины зогсоол бүхий цогцолбор байгуулан ашиглалтад оруулж, Заамар сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөнд бүртгэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		3,139,155.50	2,121,997.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	2,217,686.60	1,345,050.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	733,105.20	419,747.30
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	188,363.60	357,198.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,115,987.50	7,912,885.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,115,987.50	7,912,885.20
39200	Биет хөрөнгө		3,384,007.70	7,174,705.40
39300	Биет бус хөрөнгө	13	731,979.80	738,179.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		7,255,143.00	10,034,882.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		177,312.70	328,604.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	177,312.70	328,604.60
41300	Өглөг	17а, 17б	177,312.70	328,604.60
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,077,830.30	9,706,277.70
51	Засгийн газрын хувь оролцоо		7,077,830.30	9,706,277.70
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,319,415.20	2,257,283.20
51200	Хуримтлагдсан үр дүн		4,317,183.90	7,039,835.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		441,231.20	409,159.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		7,255,143.00	10,034,882.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,547,684.8	8,759,144.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО		3,161,053.1	3,676,911.6
110	Орлогын албан татвар		2,573,209.8	3,103,297.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		2,595,929.9	3,127,297.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-22,720.1	-24,000.0
113	Хөрөнгийн албан татвар		110,954.0	175,448.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж		476,889.2	398,165.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	644,525.8	3,894,311.1
120	Нийтлэг татварын бус орлого		644,525.8	3,844,311.1
122	Тусламжийн орлого		0.0	50,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		742,106.0	1,187,922.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,401,677.6	4,549,438.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,185,890.3	3,594,401.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,686,469.9	2,123,318.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		365,730.5	543,677.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		46,759.1	69,066.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		502,449.7	100,344.2
2104	Хангамж, бараа материалын зардал		109,952.5	123,816.8
2105	Нормативт зардал		7,872.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		47,573.0	12,800.0
2107	Томиллолт, зочны зардал		10,606.9	11,088.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		157,983.4	4,039.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		437,542.8	1,258,486.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		499,420.4	1,471,082.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		215,787.3	955,037.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		2,146,007.2	4,209,705.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		5,707,799.2	1,581,258.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-3,561,792.1	2,628,447.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,313,584.2	5,270,382.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,161,053.1	3,676,911.6
110	Орлогын албан татвар	2,573,209.8	3,103,297.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	2,595,929.9	3,127,297.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-22,720.1	-24,000.0
113	Хөрөнгийн албан татвар	110,954.0	175,448.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	476,889.2	398,165.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	32,177.1	25,098.3
1181	Газрын төлбөр	444,712.2	373,067.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	393,631.1	405,549.3
120	Нийтлэг татварын бус орлого	393,631.1	355,549.3
122	Тусламжийн орлого	0.0	50,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	758,900.0	1,187,922.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,037,226.7	3,243,466.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,037,226.7	3,243,466.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,482,668.8	1,774,176.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	365,730.5	583,787.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,274.5	69,066.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	492,117.9	79,666.4
2104	Хангамж, бараа материалын зардал	113,994.3	129,125.3
2105	Нормативт зардал	62,086.9	93,160.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,227.9	4,300.0
2107	Томилолт, зочны зардал	10,606.9	11,088.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	158,576.0	16,365.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	177,054.0	787,617.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	554,557.9	1,469,290.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,276,357.6	2,026,915.9
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,094,367.0	2,705,451.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,094,367.0	2,705,451.8
2200	Дотоод эх үүсвэрээр	1,094,367.0	2,705,451.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,094,367.0	-2,705,451.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-3,063.6	-194,100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,063.6	194,100.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,178,927.0	-872,635.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,038,759.6	2,217,686.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,217,686.6	1,345,050.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,766,110.6	0.0	13,766,110.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,252,543.4	0.0	-2,252,543.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,513,567.2	0.0	11,513,567.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-4,435,736.9	0.0	-4,435,736.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,077,830.3	0.0	7,077,830.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,077,830.3	0.0	7,077,830.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,077,830.3	0.0	7,077,830.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	2,628,447.4	0.0	2,628,447.4
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,706,277.7	0.0	9,706,277.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,108,480.9	4,118,464.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,584,299.0	1,493,337.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,563,299.0	1,472,398.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	515,783.5	500,221.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,472.9	63,578.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	679,035.9	614,948.7
2104	Хангамж, бараа материалын зардал	108,109.1	106,879.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,600.0	28,525.0
2107	Томилолт, зочны зардал	17,673.3	11,088.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,064.3	9,391.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	138,560.0	137,766.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,000.0	20,939.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,000.0	20,939.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,318,781.9	2,431,026.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	205,400.0	194,100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,108,480.9	3,818,446.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	813,339.6	792,978.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,345,802.9	2,941,669.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,949,338.4	33,798.8
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	50,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	758,705.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	458,687.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	31
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,211.8	405,773.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,211.8	176,549.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,933.5	136,181.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	43,900.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	5,487.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,400.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,867.8	1,122.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,892.9	20,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500.0	9,507.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,272.8	56,163.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,278.3	40,367.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	229,224.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,043.1	405,773.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,043.1	405,773.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	20,168.7	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.0	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай “Түүхт ой бүтээн байгуулалтыг дэмжих жил” зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 21 чиглэлийн 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 93,1 хувьтай биелүүлж, “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Тус суманд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих сумын төвөөс Баянхангай сум хүртэлх хатуу хучилттай замын ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байна, Нэгдүгээр сургуулийн өргөтгөлийн ажил 90 хувьтай, сумын цэцэрлэгт хүрээлэнгийн ажил бүрэн хийгдэж ашиглалтад орсон, шинээр цэвэрлэх байгууламж барих ажил дууссан, Төмстий багийг цахилгаан эрчим хүчинд холбох ажил дууссан, сумын төвд хатуу хучилттай зам тавих ажил 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Төв аймгийн Заамар сумын төсөвт байгууллагууд удирдах 14, гүйцэтгэх 144, үйлчилгээний 63, нийт 221 орон тоотой баталж, гүйцэтгэлээр 218 орон тоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Заамар сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналтын төлөвлөгөөг 2023 онд нийт 6 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Төсвийн 9 байгууллагад байгууллагын даргын тушаалаар тооллогын комисс гарган, хагас бүтэн жилээр тооллогыг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж, үндсэн хөрөнгийг төрийн өмчийн программд бүрэн оруулсан байна.

Заамар сумын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нэгтгэсэн тайланд хамрагдаж байгаа байгууллагаас ЗДТГ “өөрчлөлтгүй” дүгнэлт, Заамар хөгжил ОНӨААТҮГ

“хязгаарлалттай” дүгнэлт авч, ИТХ, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан, эргэлтийн эмийн сан, орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сан нь түүвэрт хамрагдсан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,779,739.3 мянган төгрөгөөр буюу 38,3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,217,686.6	1,345,050.8	-872,635.8
Авлага	733,105.2	419,747.3	-313,357.9
Бараа материал	188,363.6	357,198.9	168,835.3
Үндсэн хөрөнгө	4,115,987.5	7,912,885.3	3,796,897.8
Нийт хөрөнгө	7,255,143.0	10,034,882.3	2,779,739.3
Өр төлбөр	177,312.7	328,604.6	151,291.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,077,830.3	9,706,277.7	2,628,447.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,255,143.0	10,034,882.3	2,779,739.3

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,345,050.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 872,635.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл өмнөх оноос 608,129.9 мянган төгрөгөөр буурч 603,848.7 мянган төгрөг болсон, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 162,486.7 мянган төгрөгөөр буурч 42,271.5 мянган төгрөг болсон, эргэлтийн эмийн сангийн үлдэгдэл 4,919.9 мянган төгрөгөөр буурч 41,664.3 мянган төгрөг болсон, орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 137,531.2 мянган төгрөгөөр буурч 416,415.8 мянган төгрөг болсон нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 419,747.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 313,357.9 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн цэвэрлэх байгууламжийн ажил дуусгавар болж 537,820.6 мянган төгрөгийн авлага барагдуулсан, Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 163,895.9 мянган төгрөгөөр өсөж 345,403.4 мянган төгрөг болсон, Засаг даргын Тамгын газрын авлага 52,671.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 63,501.7 мянган төгрөг болсон нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 357,198.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 168,835.3 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын Тамгын газрын бараа материал

130,033.6 мянган төгрөгөөр өссөн, Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын бараа материал 26,974.9 мянган төгрөгөөр өссөн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бараа материал 5,399.4 мянган төгрөгөөр өссөн, Эмийн эргэлтийн сангийн бараа материал 10,052.9 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,912,885.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,796,897.8 мянган төгрөгөөр өссөн нь Гэрэлт гудамж, цэнгэлдэх хүрээлэн барих, Спорт чийрэгжүүлэлтийн танхим байгуулах, Автомашины зогсоол барих, Цэвэрлэх байгууламж байгуулах, цэцэрлэгт хүрээлэн тохижуулах, хөл бөмбөгийн талбай байгуулах зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгө 7,552,515.5 мянган төгрөг болж 3,821,739.4 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 328,604.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 151,288.9 мянган төгрөгөөр өссөн нь байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа дансны өглөг 3,570.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын өглөг 97,967.2 мянган төгрөгөөр өссөн, Заамар нэгдүгээр сургуулийн халаалтын өглөг 27,224.3 мянган төгрөгөөр өссөн, Орон нутгийн ерөнхий орлого дансны өглөг 23,446.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 9,706,277.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,628,447.4 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын Тамгын газрын эздийн өмч 4,004,384.1 мянган төгрөгөөр өссөн, Орон нутгийн ерөнхий орлого дансны эздийн өмч 631,576.5 мянган төгрөгөөр буурсан, Орон нутгийн хөгжлийн сангийн эздийн өмч 675,351.9 мянган төгрөгөөр буурсан, Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын эздийн өмч 84,532.1 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,345,050.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 872,635.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	7,576.7	64.1	-7,512.6
Төгрөг	7,576.7	64.1	-7,512.6
Арилжааны банк дахь кассын харилцах	7,576.7	64.1	-7,512.6
Банканд байгаа бэлэн мөнгө	2,210,109.9	1,344,987.6	-865,123.2
Төгрөг	2,210,109.9	1,344,987.6	-865,123.2
Төрийн сангийн харилцах	2,148,286.3	1,269,041.5	-879,244.8
Арилжааны банк дахь харилцах	61,823.6	75,945.2	14,121.6
Дүн	2,217,686.6	1,345,050.8	-872,635.8

Эх сурвалж: Заамар сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн тодруулга

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 1,269,041.5 мянган төгрөгийн 47,6 хувь буюу 603,848.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын, 32,8 хувь буюу 416,415.8 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн, 3,4 хувь буюу 42,271.5 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 16,2 хувь буюу 206,505.6 мянган төгрөгийг байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банк дахь харилцах дансанд эмийн эргэлтийн сангийн 41,664.3 мянган төгрөг, Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 34,280.8 мянган төгрөгийн үлдэгдэл байна. Арилжааны банк дахь кассад Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын 64.1 мянган төгрөг байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 879,244.8 мянган төгрөгөөр буурсан нь Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, өмнөх оноос 608,129.8 мянган төгрөгөөр буурсан, орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 137,531.3 мянган төгрөгөөр буурсан, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 162,486.7 мянган төгрөгөөр

буурсан, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн үлдэгдэл 28,903.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны Б/02 тоот захирамжаар сумын Засаг даргад, сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны Б/01 тоот захирамжаар Засаг даргын орлогч болон 4 багийн Засаг дарга нарт 15,393.6 мянган төгрөг, сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны 1 дүгээр сарын 26-ны Б/03 тушаалаар ИТХ-ын даргад 3.305.3 мянган төгрөг, нийт 7 улс төрийн албан тушаалтанд 18,698.9 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл цалин олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоож шийдвэрлэлээ.
- Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зардлын 100.0 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлыг Эргэж төлөгдөх зээлээр буруу ангилан тайлагнасан зөрчил байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 419,747.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 313,357.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	450.0	0.0	-450.0
Зээлийн хүүгийн авлага	11,732.1	12,568.1	836.0
Байгууллагаас авах авлага	618,834.8	239,844.1	-378,990.7
Хувь хүмүүсээс авах авлага	102,088.3	167,335.1	65,246.8
Дүн	733,105.2	419,747.3	-313,357.9

Эх сурвалж: Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 419,747.3 мянган төгрөгийн 39,9 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 57,1 хувийг байгууллагаас авах авлага, 3,0 хувийг зээлийн хүүгийн авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 100 хувь буюу 167,335.1 мянган төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн, байгууллагаас авах авлагын 69,0 хувь буюу 165,500.3 мянган төгрөгийн авлага нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна. Авлага дансны эцсийн үлдэгдэл 733,105.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 170,553.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 419,747.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 313,357.9 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн цэвэрлэх байгууламжийн ажил дуусгавар болж 537,820.6 мянган төгрөгийн авлага барагдуулсан, Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 163,895.9 мянган төгрөгөөр өсөж 345,403.4 мянган төгрөг болсон, Засаг даргын Тамгын газрын авлага 52,671.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 63,501.7 мянган төгрөг болсон нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар хоорондын тооцоо нийлсэн баримтгүй, 7.300.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн зөрчил байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 357,199.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 168,835.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	21,910.9	32,096.7	10,185.8
Эм боох материал	21,910.9	32,096.7	10,185.8
Хангамжийн материал	166,452.7	325,102.3	158,649.5
Бичиг хэргийн материал	1,457.0	1940.6	483.6
Аж ахуйн материал	40,503.1	167,443.2	126,940.1
Сэлбэг хэрэгсэл		1,852.0	1,852.0
Түлш, шатах тослох материал	8,087.6	913.9	-7,173.7
Барилгын засварын материал	3,000.0	0.0	-3,000.0
Бусад хангамжийн материал	113,405.1	132,952.6	19,547.5
Мал амьтад		20,000.0	20,000.0
Дүн	188,363.6	357,199.0	168,835.3

Эх сурвалж: Заамар сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бараа материалын тодруулга

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 357,199.0 мянган төгрөгийн 79,6 хувийг ЗДТГ, 9,2 хувийг эмийн эргэлтийн сан, 7.5 хувийг Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын бараа материал, 3.7 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 357,199.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 168,835.3 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын Тамгын газрын бараа материал 130,033.6 мянган төгрөгөөр өссөн, Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын бараа материал 26,974.9 мянган төгрөгөөр өссөн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бараа материал 5,399.4 мянган төгрөгөөр өссөн, Эмийн эргэлтийн сангийн бараа материал 10,052.9 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материал данстай холбоотой зөрчил илрээгүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,912,885.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,796,897.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,384,007.8	7,174,705.4	3,790,697.6
Барилга, байгууламж, орон сууц	1,819,375.7	4,303,479.8	2,484,104.1
Авто-тээврийн хэрэгсэл	560,502.4	596,576.9	36,074.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	387,559.1	373,271.7	-14,287.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	40,703.9	36,148.3	-4,555.6
Зам гүүрний байгууламж	61,363.3	48,096.1	-13,267.2
Бусад үндсэн хөрөнгө	514,503.4	1,817,132.6	1,302,629.2
Биет бус хөрөнгө	731,979.8	738,179.8	6,200.0
Программ хангамж	300.0	6,500.0	6,200.0
Бусад биет бус хөрөнгө	731,679.8	731,679.8	0
Дүн	4,115,987.5	7,912,885.3	3,796,897.8

Эх сурвалж: Заамар сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн цэвэр үлдэгдэл 7,912,885.3 мянган төгрөгийн 95.4 хувь буюу 7,552,515.5 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 4.5 хувь буюу 352,197.9 мянган төгрөгийг Заамарын хөгжил ОНӨААТҮГ, бусад 0,1 хувь буюу 8,171.8 мянган төгрөгийг ИТХ, эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,912,885.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,796,897.8 мянган төгрөгөөр өссөн нь Гэрэлт гудамж, цэнгэлдэх хүрээлэн барих, Спорт чийрэгжүүлэлтийн танхим байгуулах, Автомашины зогсоол барих, Цэвэрлэх байгууламж байгуулах, цэцэрлэгт хүрээлэн тохижуулах, хөл бөмбөгийн талбай байгуулах зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийж Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгө 7,552,515.5 мянган төгрөг болж 3,821,739.4 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт: Сумын ЗДТГ-ын эзэмшилд байгаа 13 газрыг данс бүртгэлд аваагүй, Багийн Засаг дарга нарын 4 суудлын автомашин нь ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчил байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт төлбөрийн дансны үлдэгдэл 328,604.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 151,288.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	976.7	0.0	-976.7
Ажиллагсадтай холбоотой өр	10,262.0	23,851.8	13,589.8
Байгууллагад төлөх өр	166,074.0	304,752.8	138,678.8
Дүн	177,312.7	328,604.6	151,291.9

Эх сурвалж: Заамар сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өглөгийн тодруулга

Өр төлбөр дансны үлдэгдэл 328,604.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 151,288.9 мянган төгрөгөөр өссөн нь байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа дансны өглөг 3,570.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын өглөг 97,967.2 мянган төгрөгөөр өссөн, Заамар нэгдүгээр сургуулийн халаалтын өглөг 27,224.3 мянган төгрөгөөр өссөн, Орон нутгийн ерөнхий орлого дансны өглөг 23,446.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдлийн 47,6 хувь буюу 156,526.3 мянган төгрөг нь байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн, 33,6 хувь буюу 110,516.5 мянган төгрөг нь Заамарын хөгжил ОНӨААТҮГ-ын, 10,4 хувь буюу 34,277.1 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлого дахь ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл, 8,4 хувь буюу 27,224.3 мянган төгрөг нь нэгдүгээр сургуулийн халаалтын өглөг байна.

Аудитын илрүүлэлт: Тайлант оны өр төлбөр дансны жилийн эцсийн үлдэгдэл 328,604.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар бүрэн баримтжуулсан байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 9,706,277.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,628,447.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ мянган төгрөгөөр /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,319,415.2	2,257,283.2	-62,132.0
Хуримтлагдсан үр дүн	4,317,183.9	7,039,835.1	2,722,651.2

Өмнөх үеийн үр дүн	8,752,920.8	4,411,387.7	-4,341,533.1
Тайлант үеийн үр дүн	-4,435,736.9	2,628,447.4	7,064,184.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	441,231.2	409,159.4	-32,071.8
Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл /Дүн/	7,077,830.3	9,706,277.7	2,628,447.4

Эх сурвалж: Заамар сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Заамар сумын цэцэрлэгийн хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын оруулсан капитал 62,132.0 мянган төгрөгөөр буурч, хөрөнгийн дахин үнэлгээ 32,071.8 мянган төгрөгөөр буурсан нөлөөллийг үзүүлсэн байна.

Тайлант онд гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын (Шижир алт сургуулийн 721,435.3 мянган төгрөгийн, Шижир алт цэцэрлэгийн 2,653,253.9 мянган төгрөгийн, Цэцэрлэгийн 645,895.3 мянган төгрөгийн, Эмнэлгийн 1,457,331.6 мянган төгрөгийн, соёлын төвийн 873,944.8 мянган төгрөгийн) хуримтлагдсан үр дүнг шилжүүлснээр өмнөх үеийн үр дүн буурч, тайлант үеийн үр дүн 7,064,184.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотойгоор засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,628,447.4 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Заамар сумын төсвийн байгууллагууд төсвийн төсөлд 3,161,053.0 мянган төгрөгийн орлого, зардлын саналыг төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Хүргүүлсэн төсвийн төслөөс 816.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,161,869.2 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

Сумын бүрэн эрхийн хүрээнд төсвийг батлахдаа ОНХС-д 1,306,970.0 мянган төгрөгийг, хоршоо хөгжүүлэх санд 205,400.0 мянган төгрөгийг, төсөвт байгууллагуудын зардалд 2,881,227.7 мянган төгрөгийг, аймагт төвлөрүүлэх шилжүүлэг 965,334.8 мянган төгрөгийг, нийт 5,358,932.5 мянган төгрөгийн зардал, санхүүжүүлэх нийт орлогын эх үүсвэрийг 5,358,932.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Заамар сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 08 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 3,178,369.2 мянган төгрөг, татварын бус орлогыг 93,500.0 мянган төгрөг, татварын буцаалтыг 24,000.0 мянган төгрөг, нийт татварын орлогыг 3,271,869.2 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 4,393,597.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 3,845,540.0 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах нийт зарлагыг 5,108,481.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 573,670.8 мянган төгрөгөөр, орон нутгийн шилжих үлдэгдлийг 508,898.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, Аймагт төвлөрүүлэх шилжүүлгийг 538,002.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, ИТХ-ын үйл ажиллагааны зардалд 14,068.2 мянган төгрөгийг нэмж, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт, их засварыг 530,498.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 1,477,286.6 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 205,400.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,108,481.0 мянган төгрөгөөр сумын

ИТХ-ын 2023 оны 9 дүгээр сарын 07-ний өдрийн “Заамар сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 26 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 3,845,540.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс аймгийн төсөвт олгох шилжүүлэг 1,503,337.0 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 813,339.6 мянган төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 553,947.0 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 1,193,591.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,497,235.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 555,566.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,118,464.6 мянган төгрөг буюу 80,6 хувьтай байгаа нь хөрөнгө оруулалтын зардлын төсвийг 449,070.0 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг 523,593.5 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн төсвийг 11,300.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Тусгай санхүүжилтийн орон нутгийн 4 байгууллагын байр ашиглалтын тогтмол зардалд 559,736.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	155,812.4	149,137.7	6,674.7	95.7%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	836,237.4	788,332.4	47,905.0	94.3%
3	ЕБС-үйлчилгээ	290,404.3	288,476.2	1,928.1	99.3%
4	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	122,444.6	97,030.7	25,413.9	79.2%
5	Соёл урлагийн үйлчилгээ	108,313.3	105,003.0	3,310.3	97.0%
6	ЭМТ-ийн үйлчилгээ	90,087.0	69,227.0	20,860.0	76.8%
7	Хөрөнгө оруулалтын зардал	1,822,495.3	1,373,424.6	449,070.0	75.4%
8	Орон нутгийн хөгжлийн сан	1,477,286.6	1,053,693.1	423,593.5	71.3%
9	Хоршоо хөгжүүлэх сан	205,400.0	194,100.0	11,300.0	94.5%
	Сумын дүн	5,108,480.9	4,118,464.6	990,016.3	80.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газарт 394,854.4 мянган төгрөг, ИТХ-д 10,919.4 мянган төгрөг, нийт 405,773.8 мянган төгрөг орсноос, Засаг даргын тамгын газар 355,700.7 мянган төгрөг, ИТХ 9,705.7 мянган төгрөг, нийт 365,406.4 мянган төгрөгийг зарцуулж, 40,367.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуула х төсөв	Зарцуул сан

1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч болон хороодод бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээ, мэдээллээр тасралтгүй хангаж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг жилд дөрвөөс доошгүй удаа хуралдана.	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааныг 4удаа, ГХУСА33-ийн хурлыг 3 удаа зохион байгуулж, шаардлагатай мэдээллээр тасралтгүй хангасан. Хэрэгжилт 100 хувь.	155,812.40	149,137.70
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 6 зорилт хэрэгжүүлэх 111 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.	"Түүхт ой бүтээн байгуулалтыг дэмжих жил" зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 21 чиглэлийн 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 93.1%-тай биелүүлж, "А" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.	2,658,732.7 0	2,161,756.9 0
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	Сумын хоршоод болон иргэдэд журмын дагуу 205,400 мянган төгрөгийн зээл олгоно.	194,000.0 Мянган төгрөгийн зээлийг журмын дагуу шаардлага хангасан 1 хоршоо 6 иргэнд олгосон. Хэрэгжилт 94.5 хувьтай.	205,400.00	194,100.00
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	18 зорилт 82 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.	18 зорилт 82 арга хэмжээний хэрэгжилт 94.5 хувьтай.	290,404.30	288,476.20
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	Сургуулийн өмнөх боловсролыг 10 зорилт 108 хэрэгжүүлэх арга хэмжээ, хамран сургалтыг 95 хувьд хүргэнэ.	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрөөс гадна Сумын хөгжлийн хөтөлбөр, засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөө, хүүхэд бүр цэцэрлэгт, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, чадварлаг багш хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сургуулийн өмнөх боловсрол 10 зорилт 108 арга хэмжээний гүйцэтгэлээр 98.0 хувьд хүрсэн.	122,444.60	97,030.70
6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёл урлагийн олон талт үйл ажиллагаа болон биеийн тамирын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	Соёлын төв нь 96 арга хэмжээ зохион байгуулж, соёлын арга хэмжээ, номын сангийн үйлчилгээ, соёлын биет бус өвийг өвлөн уламжлах арга хэмжээнүүдийг зохион байгуулан гүйцэтгэлийн үнэлгээгээр 95% хувьтай	108,313.30	105,003.00
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	13 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж сургалт сурталчилгаа явуулна.	13 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж сургалт сурталчилгаа явуулсан. Хэрэгжилт 98.8 хувьтай	90,087.00	69,227.00
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	Сумын хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Шилжих хөрөнгө оруулалтын 3 арга хэмжээнээс 3 арга хэмжээ, Шинээр эхлэх 8 арга хэмжээнээс 6 арга хэмжээ, Малын тоо толгойн албан татвараар санхүүжих 4 арга хэмжээнд нийт 1,053,693.1	1,477,286.6 0	1,053,693.1 0

				мянган төгрөгийн 13 хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэн ажилласан.		
9	Хоршоо хөгжүүлэх сан	2023 он	Эргэж төлөгдөх зээл	5 иргэн, 2 аж ахуйн нэгжид 194,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна. Хэрэгжилт 94.5%	205,400.0	194,100.0

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд Орон нутгийн зарлагаас давсан орлогоос /ашгаас/ санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ арьс шир боловсруулах цехийн зураг төсөв 19,000.0 мянган төгрөг, Нэгдүгээр сургуулийн хичээлийн байрны зүүн талын хэсэг, спорт урлаг заал, хүзүүвчний дээврийн засварын ажил 107,526.2 мянган төгрөг, Цагдаагийн хэлтсийн албан хаагчдын байрны засварын ажил 58,867.6 мянган төгрөг, Засмал замын уулзваруудад цагдаа стандартын 16 ширхэг камер суурилуулах 34,000.0 мянган төгрөг, Парк хороололд 04-ийн 1600 м цахилгааны шугам татах 19,800.0 мянган төгрөг, Зүүн чингэл, Баруун чингэл, Өлийн давааны зам засах ажил 19,700.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд нь худалдан авах ажиллагаа амжилтгүй болсны улмаас хэрэгжүүлээгүй байна. Энэ нь барилгын материалын үнэ өссөн, тендерт оролцогч аж ахуйн нэгж байгууллага байхгүйгээс шалтгаалсан байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны талаар

Заамар сумын Засаг дарга нь 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гаргаж батлуулан Засгийн газрын худалдан авах ажиллагааны tender.gov.mn системд байршуулсан байна.

- Эмнэлгийн гадна засварын ажил 97,649.0 мянган төгрөгөөр тендер зарлан 92,740.0 мянган төгрөгөөр Найдварт жигүүр ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Соёлын төвийн барилгын их засвар 265,147.8 мянган төгрөгөөр тендер зарлан Танан цамхаг ХХК-тай 209,988.4 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Нэгдүгээр сургуулийн гал тогооны барилгын засварын ажил 66,052.8 мянган төгрөгөөр тендер зарлан Өндөрлөг ХХК-тай 58,784.5 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Инээмсэглэл хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна фасад засварын ажил 83,538.5 мянган төгрөгөөр тендер зарлан Хас шонхор ХХК-тай 79,361.6 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Цэнгэлдэх хүрээлэн барих ажил 590,000.0 мянган төгрөгөөр тендер зарлан Хажимэ констракшн ХХК-тай 584,242.6 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Хайлааст багийн худгуудад цахим карт суурилуулах ажлыг тендер зарлан Ирмүүн бармат ХХК-тай гэрээ байгуулан 34,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.
- Төмстий багийг цахилгаан эрчим хүчинд холбох ажил 530,000.0 мянган төгрөгөөр тендер зарлан Чандмань хонгор ХХК-тай гэрээ байгуулж, 514,514.8 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.
- Тосон, Төмстий багт бэлчээрийн худаг гаргах 75,000.0 мянган төгрөгөөр тендер зарлан Буян ус ХХК-тай 75,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 1/70 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд эх сурвалжийг Төв аймгийн Заамар сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2023 оны төсвийг, суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Заамар сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 5,108,481.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 57,829.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 43,371.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар төсвийн жилийн хүрээнд 2 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 15,562.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 36,862.9 мянган төгрөг, албан томилолтын зардлаас 6,585.3 мянган төгрөг хэмнэсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдээс батлагдсан төсвөөс худалдан авахдаа бага үнийн дүнгээр гэрээ байгуулсны үр дүнд 28,390.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих 169 мэдээллээс 5 мэдээлэл хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй төлөвтэй байна. Тендер шалгаруулсан, худалдан авах ажиллагаатай холбоотой 3,080,136.2 мянган төгрөгийн 17 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5,126,038.4 мянган төгрөгийн 76 мэдээлэл, зарлагын 6,173,251.9 мянган төгрөгийн 80 мэдээлэл, төсөв өмч хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 1,107,413.4 мянган төгрөгийн 52 шийдвэрийг хугацаанд нь байршуулсан, хуулийн хэрэгжилт зөрчилгүй байна.

Нэгдсэн тайланд хамрагдагч эмийн эргэлтийн сангийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор 111,450.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.3-д харуулав.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдэж, 4 зөвлөмж өгөгдсөн байна. Эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажилласан бөгөөд сумын төсвийн орлого бүрдүүлэлтийн эрсдэлийг жилийн эцсийн байдлаар дахин горим сорил гүйцэтгэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөний хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 1/238, 239, 240 тоотой ирүүлж, fas.audit.mn системд бүрэн хэрэгжсэнээр шивсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	9614.9	1	9,614.9	100%
Албан шаардлага	1	30,979.4	1	30,979.4	100%
Зөвлөмж	2	8,000.0	2	8,000.0	100%
Нийт дүн	4	48,594.3	4	40,594.3	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дараагийн гүйцэтгэлийн аудитаар анхаарал хандуулах дараах асуудлыг тодорхойлж байна. Үүнд:

- ОНХС-г төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа, сумын иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлангийн харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланд мэдээллийг тусгахгүй орхигдуулсан 537,584.9 мянган төгрөгийн 2 алдаа, буруу тусган илэрхийлсэн 185,037.6 мянган төгрөгийн 4 алдаа, нийт 722,622.5 мянган төгрөгийн 6 алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулга хийгдсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн 7.1-д харуулав.

Аудитаар Төв аймгийн Заамар сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 93,187.3 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар нэгтгэсэн тайлангийн харьяа 2 байгууллагын 18,698.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Төлбөрийн акт тогтоогдсон зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.2-д харуулав.

5.2 Албан шаардлага

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайланд болон харьяа байгууллагын санхүүгийн тайланд албан шаардлага өгөгдөөгүй байна.

Нэгдсэн тайланд хамрагдагч эмийн эргэлтийн сангийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор 111,450.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөнийг энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.3-д харуулав.

5.3 Зөвлөмж

Аудитаар Заамар сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 93,187.3 мянган төгрөгийн 2 зөрчилд болон харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланд 7,400.0 мянган төгрөгийн 5 зөрчилд, нийт 100,587.3 мянган төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж өгч, зөвлөмж өгөгдсөн зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.2-д харуулав.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хариуцлагыг сайжруулахтай холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд 3 шатны төсвийн орлогыг нийт дүнгээр 112,5 хувиар биелүүлсэн боловч, орон нутагт төвлөрүүлэх орлогыг 97,6 хувиар биелүүлж, 2,4 хувиар буюу 93,187.3 мянган төгрөгөөр тасалж, 6 нэр төрлийн орлогыг 22,1-77,7 хувиар тасалсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлбар:

- Малын тоо толгойн албан татвар нь их хэмжээний цас орсны улмаас зам, давааны замын зорчих хэсэг хязгаарлагдаж малчдын өвөлжилт хүндэрсэн тул татварын төлөлт хийгдээгүйгээс 611,398.6 мянган төгрөгөөр,
- Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар нь орлогын төлөвлөгөө өндөр тавигдсан болон иргэдийн хөрөнгө худалдах худалдан авах хэрэглээ багассанаас 5,610.0 мянган төгрөгөөр,
- Хүү торгуулийн орлого нь төлөвлөгөө хэт өндөр тавигдсан мөн иргэд, аж ахуйн нэгжүүд зөрчил гаргах нь багассан учраас 19,934.6 мянган төгрөгөөр,
- Галт зэвсгийн албан татвар нь галт зэвсэг эзэмшигч иргэд 35 галт зэвгийг бусдад шилжүүлсэнтэй холбоотойгоор 1,050.0 мянган төгрөгөөр,
- Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний төслийг 734,221.2 мянган төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэхэд аймгийн ИТХ-ын 2022 оны 22 дугаар тогтоолоор 300,008.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,034,229.2 мянган төгрөгөөр батлагдсан. Аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 12 дугаар тогтоолоор тус сум нь хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл нөөц талбайд газрын төлбөрийг 16.0 мянган төгрөг, хөдөө аж ахуйгаас бусад уурхайн эдэлбэр ашиглалт явуулж байгаа хэсэгт 320.0 мянган төгрөг болж өөрчлөгдсөн. Энэ нь 2021 онд хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл нөөц талбайд газрын төлбөр 40.0 мянган төгрөг байснаас 24.0 мянган төгрөгөөр бууруулсан байна. 2023 онд уурхайн эдэлбэр ашиглалт явуулаагүй 16,253 га талбай буюу хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл нөөц талбайд 16.0 мянган төгрөг төлснөөр 2021 оны газрын төлбөрөөс 390,072.0 мянган төгрөгөөр газрын орлого бага орсон байна. Сумын хэмжээнд газрын төлбөрийг нэхэмжлэх үүсгэн бүрэн оруулсан. Эрд хул ХХК нь газрын төлбөрийн 255,000.0 мянган төгрөгийн өртэй байгаа бөгөөд аймгийн татварын хэлтсээс арилжааны банкны дансыг битүүмжлэх арга хэмжээ авч ажилласан байна.

1.2.Өгсөн зөвлөмж: Бүх шатны төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр нь болон нэр төрлөөр биелүүлэх.

2. Төлөвлөлт, хяналт, удирдлагыг сайжруулахтай холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн орлогын газрын төлбөр, газрын дуудлага худалдааны орлого 63,1 хувиар буюу 626,932.6 мянган төгрөгөөр тасарсан байхад, урлагийн тоглолт спортын тэмцээний орлогын албан татвар 2 дахин, аймгийн төсөвт орох Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 16 дахин, ус бохирдуулсны төлбөр 1,8 дахин давж биелсэн зэрэг төсвийн орлогын төлөвлөлтийн төслийг үндэслэлгүй боловсруулж батлуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого”, 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.”, 68 дугаар зүйлийн 68.1-д “Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална” заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.Өгсөн зөвлөмж:

Төсвийн орлогын төслийг нэр төрлөөр нь үндэслэлтэй төлөвлөж боловсруулан, танилцуулгын хамт тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж батлуулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” заалтын дагуу хүргүүлж, акт албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг дарга	1	1			1			
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Заамарын хөгжил ОНӨААТҮГ	1	1				1		
4	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан	1		1					
5	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
7	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
8	Эмийн эргэлтийн сан	1		1					
	НИЙТ	8	3	5		2	1		

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

7.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг даргын тамгын газар	3	691,590.4	1	536,573.4	2	155,017.00	3	691,590.4				

Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	111,450.5	0	0	1	111,450.5	0	0